

## БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИНТЕГРАЦИЙН ЗАРИМ АСУУДАЛД

*С.Дашцэвэл\**

Орчин үеийн шинжлэх ухаан технологийн дэвшлийн дүнд үйлдвэрлэх хүчин үлэмж нэмэгдэж даяаршил, бүсчлэл, улс орнуудын олон талт үйл явцууд нь дэлхийн эдийн засгийн хөгжлийн нэг онцлог болж байна. Эдийн засгийн харилцан хамаарал ихсэхийн хирээр эдийн засгийн өрсөлдөөн өсч байна. Зарим улс оронд үлэмж орлого олох боломж нэмэгдэж заримд нь улам хоцорч хол хаягдахын аюул нүүрлэв. Ийм үед улс орон бүр нээлттэй бодлого хэрэгжүүлж олон талт үйл явцад нэгдэхийн төлөө чармайж байна. Бүс нутгийн хамтын ажиллагааны агуулга нь эдийн засгийн хувьд хамтран ажиллах ойртон нягтрах интеграцчлах чиглэлд төвлөрөх болов.

### **1. Даяаршил ба интеграцчлал**

Хориод жилийн өмнөөс дэлхий дахинд мэдээллийн технологи, электрон техник хөгжиж эхэлсэнээс ялангуяа сансрын зайг ашиглаж алс дамжуулах мэдээллийн технологи хөгжиж ирсэн үеэс даяаршилын эрин эхэллээ. Дэлхийн аль ч өнцөгийн хүн нэгэн зэрэг интернэтээс мэдээлэл авч дэлхийн аль ч өнцөгөөс дуртай бараагаа худалдан авч банк санхүүгийн үйлчилгээ хийх гэх мэт дэлхий ертөнцийн бүх улс орнуудын орон зай багасч хил хязгаарын үүрэг нөлөө мэдэгдэхүйц буурчээ. Энэ бол хүн төрөлхтний мэдлэг оюуны хөгжлийн зүй тогтлын дагуу бий болсон бидний ухамсараас үл шалтгаалах үзэгдэл учраас улс орон бүр үүнд захирагдахаас өөр зам үгүй. Тэгэхдээ үүний дэвшилт давуу талыг аль болох бүрэн дүүрэн ашиглахын хамт үүнээс үүдэн гарах үр дагаварыг ч давхар тооцон ухаалаг хандах нь өнөө үеийн улс орон бүрийн чухал үүрэг хариуцлага болж байна.

Харин интеграцийн хувьд бол баахан өөр. Аль нэг бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцож эдийн засаг улс төрийн интеграцид нэгдэх нь тухайн орны төрийн бодлогоос хамаарах бөгөөд нэгдэх, байх нь тэр л улсын сонирхол, эрх ашгийн асуудал. Иймд интеграци нь улс орны бодлогоор зохицуулагдаж сонголт хийх боломжийг олгодог.

Хэдийгээр даяаршил, интеграцчлал хоёр нь бие биенээсээ ийнхүү ялгаатай ч хоорондоо нягт уялдаа холбоотой. Бүс нутгийн интеграцийн үйл явц хөгжих тусам даяаршилын явц түргэсэнэ.

\*С.Дашцэвэл – ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Даяаршилаас урган гарсан олон асуудал улс орнуудыг бүс нутгийн хамтын ажиллагаанд нэгтгэж эдийн засгийн интеграци руу түлхэнэ. Ийнхүү даяаршил, интеграци хоёр нь нягт харилцан шүтэлцээтэй үйл явцууд ажээ.

## **2. Бүс нутгийн хамтын ажиллагаа ба интеграцийн тухай**

Бүс нутгийн хамтын ажиллагаа нь бүсийн эдийн засаг, улс төрийн хамтын ажиллагааны энгийн хэлбэрүүдээс интеграцийн нэлээд нарийн хэлбэрүүдийг хамарсан ухагдахуун юм. Хамтын ажиллагааны энгийн хэлбэр гэдэг нь бүс нутгийнхан аливаа асуудлыг хамтран шийдвэрлэх нөхцөл бий болгох, зам тээвэр харилцаа хобооны сүлжээнд нэгдэх, хамтарч зарим хөтөлбөр хэрэгжүүлэх, хилийн худалдааны бүс байгуулах, эдийн засгийн гурвалжин байгуулах, үйлдвэрлэлийн паркуудад оролцох, хоёр болон олон талын хамтарсан үйлдвэр байгууллахыг хөхүүлэн дэмжих гм хоёр буюу түүнээс дээш орнуудын хамтарсан үйл ажиллагааг хэлнэ. Эдүгээ бүс нутгийн хамтын ажиллагааны түвшин гүнзгийрч эдийн засаг, улс төрийн интеграци руу чиглэж байна.

Бүс нутгийн эдийн засгийн интеграци гэгчийг бүдүүвч байдлаар томъёолбол нутаг дэвсгэр залгаа буюу орон зайн хувьд ойролцоо бүлэг улс үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаагаа уялдуулан зохицуулж хөдөлмөр таваар мөнгөний урсгалыг аль болохоор чөлөөтэй болгох үүднээс Засгийн газрууд харилцан үйл ажиллагаагаа нэгтгэн ажиллахыг хэлнэ.<sup>1</sup> Эдүгээ манай гариг дээр олон арван бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага бий болжээ. Дэлхийн Худалдааны Байгууллагын мэдээлж буйгаар манай дэлхийд бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны 100 гаруй ийм байгууллага холбоо байдаг аж. Тэдгээрийн 70 орчим хувь нь 90-ээд онд шинээр байгуулагджээ.<sup>2</sup> Энэ нь орчин үед даяаршилын үйл явц түргэсч дэлхийн хэмжээнд үйлдвэрлэл өргөжин хөгжихийн хамт эдийн засгийн өрсөлдөөн хүчээ авсантай холбоотой. Эдүгээ бүс нутгийн хамтын ажиллагааны интеграцийн түвшин дараах хэдэн төрөлд хуваагдаж байна. Үүнд:

- Худалдааны чөлөөт бүс. /Free Trade zone буюу Free Trade Area/ Энэ нь бүс нутагт хамрагдаж байгаа улс орнууд өөр хоорондоо худалдаа хийхдээ гааль, татварын болон бусад саад тотгорыг аль болохоор арилгаж бие биендээ худалдааны болон хөрөнгө оруулалтын хамгийн таатай нөхцөл бий болгох эрх зүйн нөхцлийг Засгийн газрууд нь харилцан тохиролцож бүрдүүлсэн байх ёстой. Бүс нутгийн эдийн

засгийн интеграцийн энэ хэлбэр хамгийн түгээмэл нь юм. Худалдааны чөлөөт бүс /FTA/-д нэгдсэн орнууд худалдаа хөрөнгө оруулалтын гааль татварыг аль болохоор хөнгөлөх буюу цэглэх, харилцан хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжихээс гадна гишүүн орнуудын хөгжлийг түргэтгэх үүднээс эдийн засгийн болон хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны төрөл бүрийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, нэвтрэн өнгөрүүлэх журам дүрэм, гаалийн бүрдүүлэлтийг хөнгөн шуурхай болгох зэрэг олон чухал арга хэмжээг Засгийн газрын түвшинд зөвшилцөн шийддэг. Гэхдээ улс орон бүр өөрийн эдийн засгийн хөгжлийн онцлог нөхцөлд тохируулан гааль татварын ялгаатай бодлого хэрэгжүүлж болдог. Гагцхүү тэр нь гишүүн бусад орнуудаар хүлээн зөвшөөрөгдсөн, өөрөөр хэлбэл бүс нутгийн интеграцийн нийтлэг зарчимд харшлаагүй байх ёстой ажээ. Мөн тухайн улс орнууд бүсийнхээ дотор чөлөөт худалдааны бодлого хэрэгжүүлээд зогсохгүй бүсийн гаднах хүссэн улс оронтойгоо худалдааг өргөжүүлэх боломжтой. Иймэрхүү худалдааны чөлөөт бүсийн нэр нөлөө бүхий томоохноос дурьдвал 1960 онд байгуулагдсан Европын чөлөөт худалдааны бүс /EFTA/, 1989 онд байгуулагдсан Умард Америкийн чөлөөт худалдааны бүс /NAFTA/, 1992 онд байгуулагдсан АСЕАН-ы худалдааны чөлөөт бүс /AFTA/ гэх мэт байна.

- Гааль татварын холбоо. /Customs Union/ Энэ нь худалдааны чөлөөт бүсээс арай илүү өндөр түвшингийн интеграцийн хэлбэр юм. Өөрөөр хэлбэл худалдааны чөлөөт бүсийн бүх онцлог шинжийг агуулсан байхын зэрэгцээ гишүүн орнууд хоорондоо худалдааны татвараас чөлөөлөгдөж бусад орнуудтай гааль худалдааны нэгдсэн тариф хэрэглэдэг.

- Нэгдсэн зах зээл. /Common Market/ Энэ нь улс хоорондын эдийн засгийн интеграцийн нэлээд өндөр түвшин юм. Үүний онцлог нь гишүүн орнууд өөр хоорондоо худалдааны таатай бүх нөхцлийг бүрдүүлж үйл ажиллагааны явцад гарах бүхий л саад бэрхшээлийг арилгахаас гадна гишүүн орнуудын хооронд хөрөнгө болон ажиллах хүч чөлөөтэй шилжих бүх нөхцлийг бүрдүүлдэг. Мөн гишүүн орнуудын үндэсний зах зээлийг зохицуулах нэгдсэн механизм үйлчилж, бусад орнуудтай харилцахдаа гадаад эдийн засгийн нэгдсэн бодлогыг мөрдлөгө болгодог.

- Эдийн засгийн холбоо. /Economic Union/ Хамтын ажиллагааны энэ хэлбэрийн онцлог нь тухайн орнууд гадаад эдийн засгийн болон хөгжлийн бодлогоо хамтран боловсруулж гишүүн орнуудын хил

хязгаарын зааг ялгаа төдийлөн ач холбогдолтой биш болдогоос гадна үндэсний эдийн засгуудыг уялдуулан зохицуулж удирдан чиглүүлэх төв аппаратыг хамтран бий болгодогт оршино. Энэ нь засгийн газруудын эдийн засгийн удирдлагыг зарим талаар орлоно гэсэн үг юм. Эдийн засгийн холбоо нь хөгжлийнхөө тодорхой шатанд мөнгө санхүүгийн холбоонд нэгдэж, нэгдсэн мөнгөн тэмдэгт хэрэглэхийн зэрэгцээ эдийн засаг санхүүгийн нэгдсэн бодлого хэрэгжүүлж тэрхүү бодлогын хэрэгжилтийг хянах механизм нь хүртэл нэгдмэл болдог. Эдийн засгийн холбоо нь улмаар улс төрийн холбоо болох чигт хөгждөг. Интеграцийн энэ хэлбэрийг одоо Европын Холбооны гишүүн орнууд хэрэгжүүлэхээр зорьж байна. Европын Холбоо нь нэгдсэн зах зээл, нэгдсэн мөнгөн тэмдэгт, нэгдсэн парламент, нэгдсэн төрийн зөвлөлтэй, нэгдсэн бодлогоор хөгжиж эдүгээ эдийн засгийн олон улсын интеграцийн дээд түвшинд ойртсоор байна.<sup>3</sup>

Гишүүн орнуудын засгийн газруудын оролцоотой бүрэлдэн бий болсон бүс нутгийн эдийн засгийн эдгээр интеграцийг олон улсын эдийн засгийн макро интеграци /Macrointegration/ хэмээн дэлхий нийтээр нэрлэж заншжээ. Үүнээс гадна олон улсын эдийн засгийн өөр нэг интеграци байх бөгөөд тэр нь улс орнуудын хувийн томоохон компани, корпорацууд эдийн засгийн интеграцид нэгдэж улс хоорондын /Multinational Company/ болон үндэстэн дамнасан корпорацууд /Transnational Company/ үүсдэгийг бид мэднэ. Түүнийг олон улсын микро интеграци /microintegration/ хэмээн нэрлэдэг. Энэ тухай энд дэлгэрэнгүй бичих боломжгүй билээ. XX зууны жараад онд анх АНУ-ын том компаниуд гадагш гарч үндэстэн дамнасан корпораци болж өргөжиж эхэлсэн бөгөөд дараа нь европын орнуудынх, 70-аад оноос японы компаниуд өргөжиж үндэстэн дамнах болов. Үндэстэн дамнасан компаниудын өсөлтийг хүснэгээр харуулбал:<sup>4</sup>

Он	1970 он	1980 он	1990 он	2000 он
Корпорацийн тоо	7000	12000	37000	60000
Салбарын тоо	27000	122000	170000	500000

Эдгээр корпорацууд одоо дэлхийн худалдааны 50 орчим хувийг, нийт хөрөнгө оруулалтын 90 шахам хувийг, шинэ техник технологийн 80 орчим хувийг эзэмшиж байна.<sup>5</sup> Үүнээс үзвэл үндэстэн дамнасан корпорацийн тоо асар түргэн өсч дэлхийн эдийн засгийг ноёрхох болжээ. Сүүлийн үед үндэстэн дамнасан корпорацууд өрсөлдөх чадвараа улам нэмэгдүүлэхийн тулд өөр хоорондоо нэгдэж аль нэг салбараар дэлхийн хэмжээнд ноёрхох нь элбэгшив.

Одоо алив улс оронд орж байгаа томоохон хөрөнгө оруулалтын үлэмжхэн хэсэг нь эдгээр үндэстэн дамнасан корпорацуудынх ажээ. Эдгээр хөрөнгө оруулалтыг авагч орнуудын хувьд анхаарах зүйл гэвэл үндэстэн дамнасан корпорацуудын хөгжлийн цаашдын хандлага, тэдний хөрөнгө оруулалт, мөнгө санхүүгийн бодлого зэргийг сайн мэдэж зөв оновчтой ашиглахын зэрэгцээ тэдний бодлого үйл ажиллагаанд ажиглагддаг зарим муу үр дагавараас болгоомжлох хэрэгтэй юм. Жишээлбэл: Эдгээр компани корпорацууд эдийн засгийн гол гол салбарыг гартаа авсан эдийн засаг санхүүгийн хувьд хүчирхэг учир алив улс орны удирдлагыг лоббидож тухайн улс орны улс төрийн амьдралд нөлөөлөх магадлал өндөр байдагаас гадна хөгжиж байгаа орнуудад хөрөнгө оруулахдаа тухайн улсын ашигт малтмал, эрдэс түүхий эдийг нээн олборлоход гол хүчээ төвлөрүүлээд буурай хөгжилтэй орны эдийн засгийн хэтийн хөгжилд чухал хэрэгтэй дэд бүтэц болон тухайн салбарыг хөгжүүлэх хэтийн зорилгод төдийлөн хувь нэмэр оруулдаггүй. Технологи шилжүүлэхийн хувьд ч байгаль орчинд халтай технологи хэрэглэх гэх зэрэг үзэгдэл багагүй тохиолддог учир засгийн газрууд эдгээрээс болгоомжилж хязгаарласан арга хэмжээг байнга авах буюу гэрээ контрактыг хянамгай хийх нь зүйтэйг судлаачид сануулдаг байна.

### **3. Бүс нутгийн хамтын ажиллагаа ба интеграцид нэгдэх нь**

Алив бүс нутгийн хамтын ажиллагаанд хамрагдах нь улс орон бүрийн хөгжлийн стратегид чухал ач холбогдолтой. Тиймдээ ч улс орон бүр аль нэг бүсийн хамтын ажиллагаанд нэгдэхийн төлөө чармайсаар байна. Энэ нь стратегийн ач холбогдолтой учраас зарим үед буулт хийх, бага зэрэг хохирол үзэх явдал ч бий. Гэхдээ алсдаа ашигтайг бодолцдог. Хэрвээ ийм стратегийн алс хэтийн ашиг хонжоог бодоогүй бол Хятад гүрэн Дэлхийн Худалдааны байгууллага /WTO/-д элсэх гэж удаа дараа элдэв буулт хийж зүтгэхгүй байсан. Европын Холбоонд орохоор өргөдөл өгөгсдийн тоо нэмэгдсээр байна. Тэдгээр орон түр зуур тохиолдох элдэв эрсдэлээс үл шантран бүс нутгийн интеграци руу зүтгэж байгаа нь мөн л хөгжлийн алс хэтийн стратегитэй нь холбоотой. Түүнээс гадна хөгжиж буй буюу буурай хөгжилтэй орны хувьд бүс нутагт нэгдэхэд хэд хэдэн ашиг хонжоо бий. Жишээ нь хөрөнгө оруулалт авах, дэвшилт технологи нэвтрүүлэх, татварын зарим хөнгөлөлт эдлэх гэх мэт. /энэ нь хоёр талын худалдаа юм уу хамтын ажиллагаанд байдаггүй зүйл/ Энэ нь эцсийн эцэст хөгжилтэй

орнуудаас буян үйлдэж байгаа зүйл ч биш харин бүс нутгийн хөгжлийн стратегид ашигтай буулт бөгөөд тэр ашиг нь эргээд очдогт хамаг учир байгаа юм.

Бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцсоноор аливаа улс орон үйлдвэрлэл технологио түргэн урагшлуулж улс орныхоо хөгжлийг түргэтгэнэ. Гэхдээ хөгжиж байгаа орны хувьд бүс нутгийн хамтын ажиллагаанд нэгдэхийн үр ашиг ба бэрхшээл хоёулаа зэрэгцэж байдаг. Хамгийн том бэрхшээл нь байгалийн баялаг болон ажиллах хүчний нөөц гэх мэт буурай хөгжилтэй орнуудын харьцангуй давуу тал, орчин үеийн аж үйлдвэр хөгжих явцад бага багаар үгүй болдогт байгаа юм. /Ер нь үйлдвэрлэл технологи хөгжсөн улс орнуудад байгалийн баялаг, хар бор хөдөлмөрийн шаардлага үгүй болдог/. Харьцангуй давуу тал нь ижилхэн олон улс орон интеграцид нэгдэх үед тэдгээр орнуудад бүр ч хүндрэлтэй. Үүнээс гадна өөр нэг хүндрэл нь интеграцитай хамт өрсөлдөөн байнга зэрэгцэж байдаг оршино. Өрсөлдөөний нэг онцлог нь бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг байнга дээшлүүлж түүний өөрийн өртөгийг бууруулахыг оролцогч орон бүрээс ямагт шаарддаг. Энэ нь хууль эрх зүйн хувьд төдийлөн дэлхийн жишигт хүрч жигдэрч чадаагүй, бүтээгдэхүүний чанар доогуур, өөрийн өртөг өндөр манай мэт оронд нилээд хүндрэлтэй гэсэн үг. Интеграцичлалд орсон орнууд юуны өмнө нийтийн чөлөөт зах зээл рүү хөл тавих ёстой. Гэтэл тэр чөлөөт зах зээл гэдэг нь гааль татварын нэгдсэн тарифт нэгдэнэ гэсэн үг. Аливаа хөгжиж буй орнууд импортын өндөр татвараар дотооддоо үйлдвэрлэж байгаа гол гол бүтээгдэхүүнийг хамгаалж байдаг. Эс тэгвээс /чөлөөт өрсөлдөөнд оролцох чадваргүй/ үндэсний үйлдвэрлэлээ дампууруулах хор уршигтай. Жишээ нь АСЕАН-ы гишүүн Вьетнам улс одоо АСЕАН-ы орнуудаас орж ирж байгаа импортын бараанаас үйлдвэрлэлээ хамгаалах үүднээс 40, 50%-ийн гаалийн татвар авдаг. Нэгэнт АСЕАН-д нэгдэж АФТА хэмээх чөлөөт зах зээлд орох болсон учир 2006 оноос АФТА-гийн нэгдсэн тарифт орох ёстой. Энэ хугацаанд үйлдвэрлэлийн өөрийн өртөгийг бууруулж бүтээгдэхүүний чанараа дээшлүүлж чадахгүй бол АФТА-гийн тарифт орох үед хамгийн их хохирол хүлээх нь тодорхой. Учир нь энэ үед тус улсын чанаргүй бүх үйлдвэрийн газар дампуурч үйл ажиллагаагаа зогсооно. Товчоор хэлбэл бүс нутгийн интеграцичлал нь аливаа орны хөгжлийн стратегид нэн чухал. Гагцхүү түүнд нэгдэх явцад тохиолддог бэрхшээл үлэмжхэн бөгөөд давж чадваас бусдын хөгжлөөс үл хоцрох, бусадтай хөл нийлүүлэн урагш хөгжих хутгийг олно.

#### 4. Монгол ба регионализм

Монгол Улс бүс нутгийн интеграцид хэзээ нэг цагт орох нь дамжиггүй. Орохын төлөө ч тэмцэх ёстой. Гэхдээ эхний шатанд бүс нутгийн хамтын ажиллагааны энгийн хэлбэрүүдэд идэвхтэй оролцож байж интеграци руу дөхөж очдог нийтлэг туршлагыг баримтлах ёстой. Манай улс Зүүн Хойд Азийн болон Зүүн Азийн /АСЕАН-ы орнуудыг оролцуулаад/ орнуудтай хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэхийн зэрэгцээ тус бүсийн олон талт хамтын ажиллагааны механизмд одооноос идэвхитэй оролцох, мөн хил орчмын эдийн засгийн бичил чөлөөт бүсүүдэд хамрагдах замаар хамтын ажиллагааг алхам алхмаар гүнзгийрүүлэх шаардлагатай юм. Улс орнууд бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцохдоо эдийн засгийн хөгжлийн түвшин, өрсөлдөх чадвар зэрэг олон хүчин зүйлээс хамаарч хир амжилттай оролцох эсэх нь шалтгаална. Бүс нутгийн эдийн засгийн интеграцид амжилттай оролцохын тулд наад зах нь дараах нөхцлийг хангасан байх ёстой ажээ. Үүнд:

1/ Гишүүн орны эдийн засаг нь зах зээлийн эдийн засгийн механизмыг чанд баримталдаг байх.

2/ Гишүүн орон нь гадны хүчний даралт шахалтаас өөрийгөө хамгаалах эдийн засгийн чадамжтай болсон байх. Өөрөөр хэлбэл тодорхой хэмжээний эдийн засгийн өрсөлдөх чадвартай байх.

3/ Бүс нутгийн бусад орнуудтай үйл ажиллагаагаа уялдуулах эрэлт хэрэгцээ буюу хүлээлт нэгэнт бий болсон байх.

4/ Олон улсын дэмжлэгийг аль болох ихээр авах, өөрийн улсын нэр хүндийг өргөх үүднээс тухайн орон дэлхийн эдийн засгийн гол төвүүдтэй сайн хөршийн буюу түншийн харилцаатай байх гэх мэт.<sup>6</sup>

Монгол Улс бусад хөгжиж буй орнуудын нэгэн адил 90-ээд оноос эдийн засгийн нээлттэй бодлогыг хэрэгжүүлж олон улсын хөдөлмөрийн хуваарь, бүс нутгийн хамтын ажиллагаанд /интеграцид / оролцох чиг бодлого баримталж байна. Чухамхүү ингэхгүйгээр хөгжих боломж үгүй юм. Одоо Зүүн Хойд Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээний механизмд оролцож эхэлсэн бөгөөд Түмэн голын хөтөлбөрт оролцохыг чармайж байна. Тус бүс нутгийн орнуудтай хоёр талын харилцааг түүний дотор худалдаа хөрөнгө оруулалт гэх мэт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлж ирлээ. Мөн Зүүн Өмнөд Азийн аюулгүйн хамтын ажиллагааны салбарт хамтран ажиллаж байна. Гэхдээ бүс нутгийн хамтын ажиллагаанд нэгдэх явц тун удаашралтай байгаа. Энэ талын хүчин чармайлт ч сул байгаа. Энэ нь олон хүчин зүйлээс шалтгаалах

зүйл боловч хамгийн гол бэрхшээл нь манай улсын эдийн засгийн бүтэц, үйлдвэрлэх хүчний чадавхитай холбоотой болов уу. Монгол Улс газар нутаг уудам, байгалийн баялагаар элбэг, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд арвин гэх мэтээр бид ярьдаг. Энэ нь улс орныг хөгжүүлэхэд түшиглэх давуу тал мөн боловч улс орны эдийн засгийн чадамж биш. Эдүгээ энэхүү давуу талаа түшиглэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гол нь гүн боловсруулалт хийж эцсийн бүтээгдэхүүн гаргах, тэр нь дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц өртөг багатай шилдэг бүтээгдэхүүн байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүний тул хөгжингүй орнуудтай хамтарсан үйлдвэрүүдийг байгуулж дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх явдал юм. Иймэрхүү хамтарсан үйлдвэрүүдийг бий болгох хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулж хамгийн таатай нөхцлийг бүрдүүлж өгөх нь нэн чухал. Азийн олон орон эдийн засгийн онцгой болон чөлөөт бүсүүд, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийн парк, өндөр технологийн болон үйлдвэрлэл үйлчилгээний паркуудыг байгуулж байгаа нь чухамдаа гадаадын хөрөнгө оруулалтыг татах шилдэг арга ажээ.

Байгалийн баялаг бол хэзээ нэг цагт дуусна. Харин мал аж ахуй хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд түшиглэсэн орчин үеийн үйлдвэрлэл бидэнд их ирээдүйтэй учир үүнд хөрөнгө оруулах хөгжингүй орнуудыг татах бодлого нэн чухал юм.

Үүнээс гадна алив орон хөгжиж бусдын дайтай явъя гэвэл шинжлэх ухаан боловсролыг эн тэргүүнд тавьж түүнд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжийг дээд зэргээр ашиглах ёстой билээ. Одоо хөгжиж буй орнуудын нэг гол бодлого бол бусдын хөгжлийг түргэн гүйцэхийн тул оюунлаг эдийн засгийг хөгжүүлэх явдал болоод байна. Энэ нь Монгол орны хувьд нэн чухал бөгөөд хэрэгжүүлэх боломжтой салбар гэдэг нь тодорхой. Оюунлаг эдийн засгийг хөгжүүлснээр:

- Мэдээллийн технологи, электроникийн үйлдвэрлэл хөгжүүлэх
- Биотехнологийн үйлдвэрлэлийн чиглэлд амжилт гаргах
- Мал аж ахуйн гаралтай түүхий эдээ бүрэн боловсруулж дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн гаргах, түүнд тохирсон үндэсний технологийг бий болгон байнга хөгжүүлэх

- Уул уурхайн эрдэс баялгийн боловсруулалтын түвшинг дээшлүүлж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох гэх мэт амжилтанд хүрэх боломж бүрдэнэ.

Ийнхүү үйлдвэрлэх хүчин, эдийн засгийн чадамжаа дээшлүүлж дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн төлөө чармайх

нь бүс нутгийн интеграцид амжилттай оролцох таатай нөхцлийг бүрдүүлэх юм. Аливаа бүс нутгийн интеграцид оролцоно гэдэг нь хамтран ажиллах, өрсөлдөн тэмцэх хоёр үйл явц зэрэгцэж байж сая харьцангуй давуу талаа үр ашигтай нээн олох явдал билээ. Ер нь орчин үеийн хамтын ажиллагаа буюу интеграцийн нэг онцлог нь хамтрахын зэрэгцээ өрсөлдөж байж сая амжилтанд хүрдэг жамтай ажээ. Бүс нутгийн хамтын ажиллагааны өрсөлдөөнд ялагдваас харилцан хамаарал бүхий эрх тэгш түнш биш эрхшээл нөлөөнд автагдсан эдийн засгийн дагуул орон болж хувирах буюу эсвэл эдийн засгийн үр ашгийг төдийлөн санасан хэмжээгээр хүртэж чадахгүй хохирох явдал олонтаа ажээ.

Бүс нутгийн интеграцид оролцоходоо бид эдийн засгийн харилцан хамаарал бүхий эрх тэгш түнш болохын төлөө тэмцэх ёстой. Харилцан хамаарал гэдэг бол хэн нэгний эрхшээлд орно гэсэн үг биш. Харилцан хамаарал нь аль нэг улс орны тусгаар тогтнол, эдийн засгийн бие даасан байдал, өвөрмөц соёлтой зөрчилддөггүй. Гагцхүү нэгний эрх ашиг нөгөөгийн эрх ашигт захирагддаг ерөнхий зарчимтай.

Өрсөлдөх чадварын тухайд гэвэл өрсөлдөх чадвар сайтай байх тусам интеграцид амжилттай оролцоно. Интеграцид нэгдэх нь эргээд эдийн засгийн давуу талаа бий болгож өрсөлдөх чадвараа улам нэмэгдүүлэхэд туслана. Иймд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн төлөө тэмцэл бол аль болох эрт эхлэх ёстой байнгын шинжтэй тэмцэл ажээ. Энэ бол зах зээлийн эдийн засгийн гол шинжтэй нягт холбоотой улс орны стратегийн гол асуудлын нэг юм.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Nguyen thi Hien, Hoi nhap kinh te khu vuc /Бүс нутгийн эдийн засгийн интеграци/. Hanoi, tr.44 ,Vo Dai Tuoc, tr.9
2. Quan he kinh te quoc te /Олон улсын эдийн засгийн харилцаа/, Hanoi, 2003, tr. 9
3. Мөн тэнд. 40-42-р тал
4. Мөн тэнд. 67-р тал
5. Tran Khanh, Lien ket ASEAN trong boi canh toan cau hoa /Даяаршлын нөхцөл дэх АСЕАН-ы интеграци/ Ha Noi, 2002, Tr.86.
6. Vo Dai Luoc, Ta Kim Ngoc. Sac khoi kinh te va mau dich tren the gioi /Дэлхийн эдийн засаг худалдааны бүсүүд/ Ha Noi, 1996, tr.9.